



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/62

Хөхөө

Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах
ажлын хэсэг байгуулах, төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн дугаар А/306 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Ахлагч: З.Анхсанчир- Засаг даргын орлогч

Гишүүд: Д.Болд-Эрдэнэ – Санхүү албаны дарга

С.Туваансүрэн – Нийгмийн даатгалын байцаагч

С.Оюундарь– Татварын улсын байцаагч

Г.Чулуунбаатар – Газрын даамал

Х.Насанжаргал – Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

Б.Баярцэцэг – Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн

П.Бямбасүрэн - Байгаль хамгаалагч

Б.Мөнхгэрэл - Байгаль хамгаалагч

С.Отгонжаргал – Нярав

Д.Баяржаргал – Нягтлан бодогч

Д.Өлзийсайхан – Мал эмнэлгийн улсын байцаагч

Л.Бумбаяр – Тархвар зүйч

Д.Мөнгөнцэцэг – Цаг уурын харуул

А.Отгонбаяр – Ерөнхий боловсролын сургуулийн захирал

Д.Оюунчимэг – Соёлын төвийн дарга

Ц.Цэрэнчимэд - Эрүүл мэндийн төвийн дарга

Б.Өлзий - Жаргалан хүүхдийн цэцэрлэг эрхлэгч

Б.Энхбаатар – Эрчим хүчний салбар хариуцсан техникч

П.Оргил – Шивэрт багийн Засаг дарга

З.Мөнхбат – Ёлгос багийн Засаг дарга

Н.Эрдэнэбаяр – Улаан-Асга багийн Засаг дарга

З.Дашням – Хөхөө багийн Засаг дарга

Ц.Гансүх – Хайрхан толгой багийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Б.Энхзул – Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

2.Сумын хэмжээнд өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулах, удирдлага арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах албан тушаалтнуудын хуваарийг

хавсралт 1-ээр, хөдөө аж ахуйн салбарын болон төв суурин газрын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах ажлын төлөвлөгөөг хавсралт 2-оор тус тус баталсугай.

3.Сумын хэмжээнд өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг зохион байгуулж, ажлын явцын талаарх мэдээллийг Сумын Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Засаг даргын орлогч (З.Анхсанчир)– д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Баасанжав) – д даалгасугай.

ДАРГА

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is written in a cursive style, crossing the stamp.

Л.ЭНХЖАРГАЛ

Сумын Засаг даргын 2024 оны 07 дугаар
сарын 18-ны өдрийн А/62 тоот
захирамжийн хавсралт-1

БАГ, БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙ НЭГЖҮҮДИЙН ӨВӨЛЖИЛТ,
ХАВАРЖИЛТЫН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГУУЛАХ АЛБАН ТУШААЛТНУУДЫН
ХУВААРЬ

№	Баг байгууллага, аж ахуй нэгжийн нэр	Хариуцах албан тушаалтаны нэр	Албан тушаал
1	Шивэрт баг	П.Оргил, Д.Болд-Эрдэнэ	Шивэрт багийн засаг дарга Санхүү албаны дарга
2	Ёлгос баг	Б.Энхзул З.Мөнхбат Д.Мөнгөнцэцэг	Мал аж ахуйн мэргэжилтэн Ёлгос багийн засаг дарга Цаг уурч
3	Улаан-Асга баг	Н.Эрдэнэбаяр Т.Алтанчимэг	Улаан-Асга багийн засаг дарга Нийгмийн бодлогын мэргэжилтэн
4	Хөхөө баг	Г.Чулуунбаатар Б.Баярцэцэг З.Дашням Б.Энхбаатар	Газрын даамал Хууль эрхзүй хариуцсан мэргэжилтэн Хөхөө багийн засаг дарга Эрчим хүчний салбар хариуцсан техникч
5	Хайрхан толгой баг	Д.Өлзийсайхан Ц.Гансүх П.Бямбасүрэн	Мал эмнэлгийн улсын байцаагч Хайрхан толгой багийн засаг дарга Байгаль хамгаалагч
6	Ерөнхий боловсролын сургууль	А.Отгонбаяр Б.Мөнхгэрэл	Ерөнхий боловсролын сургуулийн захирал Байгаль хамгаалагч
7	Эрүүл мэндийн төв	Ц.Цэрэнчимэд С.Оюундарь	Эрүүл мэндийн төвийн дарга Татварын байцаагч
8	Хүүхдийн цэцэрлэг	С.Туваансүрэн Б. Өлзий	Нийгмийн даатгалын байцаагч СӨБ-ын эрхлэгч
9	Соёлын төв	Д.Оюунчимэг Д.Баяржаргал	Соёлын төвийн дарга Нягтлан
11	Аж ахуй нэгжүүд	Х.Насанжаргал С.Отгонжаргал	Хөдөө аж ахуйн мэргэжилтэн Нярав

Сумын Засаг даргын 2024 оны 07 дугаар
сарын 18-ны өдрийн А/62 тоот
захирамжийн хавсралт-2

ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН 2024-2025 ОНЫ ТӨВ СУУРИН ГАЗАР БОЛОН
ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ӨВӨЛЖИЛТ, ХАВАРЖИЛТЫН БЭЛТГЭЛ ХАНГАХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийж хэрэгжүүлэх ажил үйлчилгээ	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Хугацаа	Хяналт тавих
1	2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулах.	ХАА-н тасаг, Төсвийн байгууллагууд	6-9 сард	ЗДТГ
2	Хүнс, Хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А/71 тоот тушаалаар батлагдсан өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, шалгах, дүгнэх зааврын дагуу төлөвлөлт хийж хэрэгжилтийг ханган ажиллах	ХХА-н тасаг, багийн дарга нар	6-11 сард	ЗДТГ
3	Малын тэжээлийн чиглэлээр сургалт, мэдээлэл зохион байгуулах	Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн Х.Насанжаргал, багийн дарга нар	6-10 сард	ЗДТГ
4	Хаврын тариалалтын мэдээлэл гаргах	Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн Х.Насанжаргал	6-7 сард	ЗДТГ
5	Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангаж, малын хашаа хорооны засвар үйлчилгээ, өтөг бууц бэлтгэх, дулаалга, ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээг эртнээс сайтар зохион байгуулах	Багийн засаг дарга нар, Б.Энхзул-ХААТ-н мэргэжилтэн, Мал эмнэлгийн улсын байцаагч Д.Өлзийсайхан, Тархвар зүйч-Л.Бумбаяр	07-10 сард	ЗДТГ
6	Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд Ерөнхий боловсролын сургууль, Жаргалан хүүхдийн цэцэрлэг, Хүн эмнэлэг, Соёлын төв, Засаг даргын тамгын газар зэрэг төсвийн байгууллагууд хамтарч ажиллах.	Төсвийн байгууллагууд	08-10 сард	ЗДТГ
7	Багийн түвшинд мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх малчин өрхөд малын тоонд тулгуурлан бэлтгэх өвс тэжээлийн даалгавар өгч биелэлтийг тооцож ажиллах.	Багийн засаг дарга нар	08-10 сард	ЗДТГ

8	Хадлан тэжээл бэлтгэх техникийн засвар үйлчилгээг эхлүүлж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.	ХАА-н тасаг, багийн засаг дарга нар	08-10 сард	ЗДТГ
9	Аймгаас өгсөн өвс тэжээлийн төлөвлөгөөг /сумын аюулгүйн нөөц бүрдүүлэх/ биелүүлэх, орон нутгийн нөөц боломжийг ашиглан өвс тэжээлийн илүү их нөөц бүрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах	Төсвийн байгууллагууд	08 - 09 сард	ЗДТГ
10	Мал сүргийг мал эмнэлгийн намрын арга хэмжээнд бүрэн хамруулах тарилга туулгалт, угаалгыг чанартай зохион байгуулж хамрагдсан малын тоо мэдээ, тайланг хугацаанд нь ирүүлэх.	Мал эмнэлгийн улсын байцаагч Д.Өлзийсайхан,Тархвар зүйч Л.Бумбаяр	07-10 сард	ЗДТГ
11	Баг бүрт бэлчээрийн ургац, даац багтаамжийг тодорхойлох өвөл хаврын улирлын бэлчээрийн даацыг тодорхойлж танилцуулах.	Цаг уурч Д.Мөнгөнцэцэг Газрын даамал Г.Чулуунбаатар, ХАА-н тасаг	08-11 сард	ЗДТГ
12	Отроор өвөлжих өрх, малын судалгааг гаргаж отор оруулах сумуудтай гэрээ байгуулах,отроор өвөлжих өрхтэй 2 сумын Засаг даргын гэрээ байгуулах.	Багийн засаг дарга нар , Бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн Х.Насанжаргал	08-10 сард	ЗДТГ
13	Отроор өвөлжих малчдын малыг ээмэгжүүлэн, бүртгэл мэдээллийн цахим санд оруулах	Б.Энхзул-ХААТ-н мэргэжилтэн Багийн засаг дарга нар	09-11 сард	ЗДТГ
14	Намрын ургац хураалтын бэлтгэл ажлыг хангах, техник засварын үйлчилгээг хугацаанд гүйцэтгэх.	Багийн засаг дарга нар	09-10 сард	ЗДТГ
15	Цочир хүйтрэл, их хэмжээний цас, хүчтэй салхи, мөндөр зэрэг цаг агаарын аюултай үзэгдлийн урьдчилсан мэдээ мэдээллээр малчид,тариалагчид, иргэдийг тогтмол хангах.	Цаг уурын харуул Д.Мөнгөнцэцэг	08-11 сард	ЗДТГ
16	Намрын ургац хураалтыг технологийн дагуу цаг хугацаанд нь гүйцэтгэж,мэдээ тайланг бодитоор цаг хугацаанд нь гаргаж өгөх.	Бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн Х.Насанжаргал	09-10 сард	ЗДТГ
17	Малчин өрх бүр өөрсдийн бололцоогоор өвөлжилтийн бэлтгэл хангаж,малын хашаа хорооны дулаалга, ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээг эртнээс сайтар зохион байгуулах	Багийн засаг дарга нар, Б.Энхзул-ХААТ-н мэргэжилтэн, Д.Өлзийсайхан- Мал эмнэлгийн улсын байцаагч, Л.Бумбаяр-Тархвар зүйч	08-10	ЗДТГ
	Отроор өвөлжиж, хаваржиж байгаа малчдын талаарх	Багийн засаг дарга нар, Мал эмнэлгийн		

18	судалгааг үндэслэн эрүүл мэндийн явуулын үйлчилгээ үзүүлэх хуваарь гаргаж ЭМГ –т хүргүүлэх.	улсын байцаагч Д.Өлзийсайхан,Тархвар зүйч Л.Бумбаяр	09-10 сард	ЗДТГ
19	2023-2024 онд хэрэгцээлэх, зах зээлийн эргэлтэнд оруулах малын тоо хэмжээг малын төрөл, сүргийн зохистой харьцаанд тулгуурлан багийн хамжээнд тоог нэгтгэн судалгааг МҮА-д хүргүүлэх	ХАА-н тасаг, Багийн засаг дарга нар	09 – р сард	ЗДТГ
20	Хадлан тэжээл бэлтгэх,ургац хураалтын үед хэрэглэх бензин,дизель түлш,шатах тослох,материалын нөөц бүрдүүлэх,хомсдол үүсгэхгүй байх тал дээр төлөвлөгөө гаргаж ажиллах.	ХАА – н тасаг ,ШТС-ын эрхлэгч нар	08-10 сард	ЗДТГ
21	Цаг үеийн ажлын мэдээ тайланг үнэн бодитоор цаг хугацаанд нь гаргаж ирүүлэх.	Багийн засаг дарга нар , ХАА-н тасаг	08-10 сард	ЗДТГ
22	Гадна аймагт болон өөрийн аймгийн бусад сумдад отроор өвөлжих өрхийн малд нэг бүрчлэн үзлэг хийж өрхийн дэвтэр хөтлөх,гоц халдварт өвчний талаар мэдээлэл хийж зөвлөгөө өгөх	Д.Өлзийсайхан-Мал эмнэлгийн улсын байцаагч Л.Бумбаяр-Тархвар зүйч	08-11 сард	ЗДТГ
23	Өвлийн их ачаалалд тохируулан тоног төхөөрөмжийн тохируулга хийх.	Сумын цахилгаан эрчим хүч	09 -10 сард	ЗДТГ
24	Албан байгууллага, аж ахуй нэгжүүд өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллах хүч, техник тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах.	Төсвийн болон аж ахуй нэгж байгууллага	09 сард	ЗДТГ
25	Суурин газрын худаг усан сангийн засвар, дулаалга, шинэчлэлтийн ажлыг дулааны улиралд бүрэн хийж гүйцэтгэх.	4 багийн засаг дарга, ЗДТГ –ын нярав	09 сар	ЗДТГ
26	Өвөлжилт хаваржилтийн бэлтгэл хангах, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нөөц бүрдүүлэх.	Багийн засаг дарга нар, ЗДТГ –ын нярав	09 сард	ЗДТГ
27	Харилцаа холбоо, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн шаардлагатай засварын ажлыг хийж гүйцэтгэх, өвөлжилт, хаваржилтийн бэлэн байдлыг хангах	Төсвийн байгууллага, аж ахуй нэгжүүд	09 сард	ЗДТГ
28	Зам даваа хаагдсан үед ашиглах техник хэрэгсэл, хүн хүчний бэлэн	Төсвийн байгууллагууд	08-10	ЗДТГ

	байдлыг хангах		сард	
29	Сумын төвийн хүн амын өвөлжилт, хаваржилтийн бэлтгэх хангах, нэн тэргүүний хүнсний хэрэгцээ, түлээ түлшний нөөцийг бүрдүүлэх	ХААТ, Багийн дарга нар	08-10 сард	ЗДТГ

___оОо___